

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|-----|---|-----|
| 89. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 346 |
|-----|---|-----|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|---|-----|
| 90. | Улсын Их Хурлын 2010 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Дугаар 10 | 346 |
| 91. | Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 11 | 350 |
| 92. | Тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 12 | 354 |
| 93. | Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 14 | 354 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|-----|---|-----|
| 94. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилгох тухай Дугаар 01 | 355 |
| 95. | Элчин сайдыг томилгох тухай Дугаар 06 | 355 |
| 96. | Элчин сайдыг томилгох тухай Дугаар 07 | 356 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 97. | Журам батлах тухай Дугаар 368 | 356 |
|-----|--|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 02 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 26.3.7 дахь заалт нэмсүгэй:

"26.3.7.өмнөх ээлжит болон нөхөн сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийн "улсын орлого болгох тухай" гэсний дараа "болон энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах тухай" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 02 дугаар сарын 04 -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын 2010 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2010 оны хаврын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2009 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Дампуурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд;

5/Өрсөлдөөний тухай хуулийн төсөл;

6/Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

7/Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

8/Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

9/Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн



тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэстний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

10/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

11/Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай /Шинэчилсэн найруулга/, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд;

12/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай /Шинэчилсэн найруулга/, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд;

13/Монгол Улсын Эрүүгийн (Төрөлжсөн) хуулийн төсөл, Монгол Улсын Эрүүгийн /Төрөлжсөн/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд;

14/Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

15/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

16/Төсвийн тухай хуулийн төсөл;

17/Инновацийн тухай хуулийн төсөл;

18/Цагдаагийн байгууллагын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

19/Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

20/Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

21/Төрийн албан дахь ажиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл;

22/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслүүд /Шинэчилсэн найруулга/;

23/Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн төсөл;

24/Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл;

25/Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл;

26/Нийгмийн халамжийн багц хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

27/“Ус” үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

28/“Монгол мал” үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

29/Бусад.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, мөн энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг 2010 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3. Улсын Их Хурлын 2010 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоолд заагаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас 2010 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор өргөн мэдүүлбэл мөн оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4. Улсын Их Хурлын 2010 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Засгийн газар /С.Батболд/, Байнгын хороодын дарга, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ахлагч нар болон Тамгын газар /Ц.Шаравдорж/-г тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 02 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь.

1.Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл-ийг хавсралтаар баталсугай.

2.Дараахь асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

1/Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор баталсан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн Монгол Улсын төрд ногдох хувьцааг дангаар болон ордын төрөл, чиглэлээр бүлэглэн Хүний хөгжил сангийн тухай хуульд нийцүүлэн байгуулсан хувьцаат компанид шилжүүлэн, түүний хувьцааны тодорхой хэсгийг дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд үе шаттайгаар арилжаалах.

2/Энэ тогтоолын 2 дахь заалтын 1 дэх дэд заалтад заасан компанийн хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд арилжаалах бодлого, төлөвлөгөө /загвар/ болон бусад аргачлалыг төсөл тус бүрээр хувилбартай боловсруулах.

3 Төрийн өмчийг өөрчлөн байгуулах /хувьчлахгүйгээр/ хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

1/Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийг байгуулах тухай хоёр улсын Засгийн газар хоорондын 1949 оны хэлэлцээрийг Монгол Улсын хүчэн төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, төрд ногдох хувийг 51-ээс доошгүй хувьд хүргэх;

2/Хөтөлийн "Цемент шохой" ХХ-ийн цемент үйлдвэрлэх



технологийг хуурай аргад шилжүүлэх нөхцөлтэйгээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2010 оны
11 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙГ 2010-2012 ОНД
ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ**

Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн зорилго нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасан хувийн хэвшил тэргүүлсэн адийн засгийн эрчимтэй өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Өмч хувьчлалыг хийхдээ уламжлалт арга, хэлбэрийн зэрэгцээ төрийн өмчит хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих, нэмэлт хувьцаа гаргаж нийтэд санал болгох, концессын гэрээ байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бусад хэлбэрийг ашиглан хувийн хөрөнгө оруулалтыг татах аргыг голлоно.

Нэг. Өмч хувьчлалын үндсэн зарчим

1.1.Төрийн өмчийг хувьчлахад дараахь зарчмыг баримтална:

1.1.1.эдийн засаг дахь төрийн хувь хэмжээг багасгаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

1.1.2.төрийн өмчийн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тариф зах зээлийн зарчмаар тогтох боломжийг нэмэгдүүлэх;

1.1.3.төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнтэй арга, хэлбэрийг нэвтрүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд олон улсын дэмжлэг, зөвлөгөөг ашиглах;

1.1.4 хувьчлагдаж байгаа хуулийн этгээдийн ажиллагсадын нийгмийн хамгааллын асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх.



Хоёр.Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зохион байгуулалт

2.1.Үндсэн чиглэлийг дараахь зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ:

2.1.1.хувьчлах төрийн өмчит хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, энэ жагсаалтад орсон хөрөнгө /объект/-ийг хувьчлах арга, хэлбэрийг Засгийн газар жил бүр баталж, Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг Улсын Их Хуралд жил бүр тайлагнах;

2.1.2.хувьчлах төрийн өмчит хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтад орсон хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгө /объект/-ийг хувьчлах үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулах.

Гурав.Өмч хувьчлалын арга, хэлбэр

3.1.Төрийн өмчийн хувьчлалд дуудлага худалдаа, олон улсын уралдаант шалгаруулалт /тендер/ зэрэг уламжлалт аргын зэрэгцээ хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих, тухайн компанийн ажиллагсдад зориулан "Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт шаардлагатай компанийн хувьд нэмэлт хувьцаа гаргаж дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдаалах болон концессын гэрээ байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бусад аргыг түлхүү хэрэглэнэ.

Дөрөв.Өмч хувьчлалын талаархи мэдээлэл

4.1.Өмч хувьчлалын талаархи мэдээллийг нийтэд адил тэгш, хүртээмжтэй хүргэж, өөрчлөн байгуулалт, хувьчлалыг ил тод явуулна.

4.2.Хувьцаа эзэмшигч, хувьчлалд оролцогч, сонирхогч этгээдийг шаардлагатай мэдээллээр хангах, тэдэнд чөлөөтэй сонголт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор мэдээллийг тогтмол хүргэнэ.

Тав.Өмч хувьчлалд хамрагдах төрийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийг хувьчлах арга

5.1.Багануур" ХК-ийн нүүрсний нөөцийг олон улсын стандартын дагуу үнэлж, эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийг хөрөнгийн үнэлгээнд оруулан цахилгаан станц барих, нүүрс шингэрүүлэх зэрэг төслүүдийг мэргэжлийн судалгаа хийсний үндсэн дээр боловсруулж, хэрэгжүүлэх

эх үүсвэрийг төрийн мэдлийн хувьцаа нь 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган арилжаалах замаар бий болгоно.

5.2. "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ХК-д нэмэлт хөрөнгө оруулалт хийх, дулаан үйлдвэрлэлтийн хүчин чадлыг өсгөх, бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах нөхцөлтэйгээр концессын гэрээгээр ашиглах үндэсний хөрөнгө оруулагчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгоно.

5.3. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ХК-д нэмэлт хөрөнгө оруулалт хийх, хүчин чадлыг өсгөх, бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах нөхцөлтэйгээр концессын гэрээгээр ашиглах үндэсний хөрөнгө оруулагчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгоно.

5.4. Цахилгаан түгээх компаниудыг өргөтгөх, техник, технологийг шинэчлэх, зардал бууруулах, үйлчилгээний шуурхай, найдвартай байдлыг хангах зорилгоор тэдгээрийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар үндэсний компанид хувьчилна.

5.5. "Монголын Хөрөнгийн бирж" ХК-ийг мэргэжлийн өндөр түвшний олон улсын удирдлагын багаар удирдуулах замаар үйл ажиллагааг нь сайжруулсны үндсэн дээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилна.

5.6. "Эрдэнэ зам" ХК-ийг Япон Улсын талаас зөвшөөрөл авсны үндсэн дээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилна.

5.7. "Авто импекс" ХК-ийг төсөвт төлөх дотоод, гадаадын зээлийн өрийн хамт нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилна.

5.8. "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг БНСУ-ын "Корей Телеком" компанид гэрээний дагуу эхний ээлжид санал болгож, татгалзсан тохиолдолд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилна.

5.9. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилна.

5.10. "Улаанбаатар Авто замын засвар арчлалт" /Улаанбаатар АЗЗА/ ХК-ийн 51 хувийг төрийн мэдэлд хэвээр үлдээж, үлдсэн 49 хувийг концессын гэрээгээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зарчмаар хувьчилна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 02 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 02 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орлуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Алтангэрэл, Ламжавын Гүндалай, Содномзундуйн Эрдэнэ нарыг Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Финланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Баярыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Финланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Балдангийн Энхмандахыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хараавчийн Аюурзаныг Бүгд Найрамдах Киргизстан Улсад хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хараавчийн Аюурзаныг Бүгд Найрамдах Тажикистан Улсад хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 368

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн албан хаагчдыг орон сууцны эзэлд хамруулах журмыг хэвсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
 ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
 ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛД ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь тогтоосон шалгуурыг хангасан төрийн албан хаагч (цаашид "зээлдэгч" гэх)-д арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцыг худалдан авахад зориулан зээл олгох, эргэн төлүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Зээлийн зориулалт, шаардлага

2.1. Энэхүү зээл нь арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцыг төрийн албан хаагч худалдан авахад зориулагдана.

2.2. Зээлийн хэмжээ нь 40.0 (дөч) хүртэл сая төгрөг байна.

2.3. Зээл нь 20 хүртэл жилийн хугацаатай, зээлийн хүү нь жилийн 8 хүртэл хувь байна.

2.4. Орон сууцны урьдчилгаа төлбөр нь худалдан авах орон сууцны үнийн дүнгийн 10 хувиас доошгүй байна.

2.5. Зээлдэгчийн зээлээр авч байгаа орон сууц нь зээлийн барьцаа болно.

2.6. Зээлдэгч хүүгийн төлбөрийг бууруулах зорилгоор гэрээнд заасан хуваарьт төлбөрөөс урьдчилан төлж болох бөгөөд хүүг зээлийг ашигласан хугацаагаар тооцно.

Гурав. Зээлдэгчид тавигдах шалгуур

3.1. Зээлдэгч нь төрийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, цаашид тогтвор суурьшилтай ажиллах төрийн албан хаагч байна.

3.2. Зээлдэгчийн сард төлөх зээл, хүүгийн нийт төлбөр нь тухайн өрхийн сарын дундаж орлогын 45 хувиас хэтрэхгүй байна.



3.3. Зээл авах хүсэлт гаргаж байгаа төрийн албан хаагч энэ журмын 2.3-т заасан хугацаанаас өмнө тэтгэвэрт гарах тохиолдолд урьдчилгаа төлбөрийг нэмэгдүүлэн төлөх боломжтой байна.

3.4. Зээл авах хүсэлт гаргаж байгаа төрийн албан хаагч нь банк, банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, зээлгүй байна.

Дөрөв. Төрийн байгууллагын хүлээх үүрэг

4.1. Эрх бүхий байгууллагаас тогтоосон зээлийн орон сууцны тооны хязгаарт багтаан тухайн төрийн албан хаагчдад зээл олгуулах асуудлыг төрийн байгууллага нь байгууллагын нийт ажилчдын хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргана. Төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийг энэхүү журмын хавсралтад заасан бүрдүүлэх бичиг баримтын хамт Орон сууцны санхүүжилтийн корпораци (цаашид ОССК гэх)-д хүргүүлнэ.

4.2. Төрийн байгууллага нь ОССК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, тухайн төрийн албан хаагчийн зээлийн төлбөрийг гэрээний дагуу сар бүр цалингаас нь суутган шилжүүлж байна.

4.3. Зээлдэгчийн ажлын байр өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх байгууллагын чиг үүргийг нь хэрэгжүүлж байгаа, шилжсэн тохиолдолд үргэлжлүүлэн ажиллуулж байгаа байгууллага тус тус энэхүү журмын 4.2-т заасан үүргийг хүлээнэ.

4.4. Зээлдэгч ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, шилжсэн тохиолдолд төрийн байгууллага энэ тухай ажлын 3 хоногт багтаан ОССК-д мэдэгдэнэ.

Тав. Зээлийн орон сууцанд тавигдах шаардлага

5.1. Зээлийн орон сууц нь арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа, шинэ орон сууц байна.

5.2. Зээлийн орон сууцыг улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

5.3. Зээлээр олгох орон сууцны 1м^2 талбайн үнэ 650,000 төгрөг буюу түүнээс хямд байна.



Зургаа. Орон сууцны санхүүжилтийн корпорацийн
хүлээх үүрэг

6.1. Төрийн албан хаагчийг орон сууцны зээлд хамруулахаар төрийн байгууллагаас ирүүлсэн бичиг баримтыг хүлээн авч хянаж, судална.

6.2. ОССК нь зээл олгох шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан гаргана.

6.3. ОССК нь зээл олгох, эсэх талаар гаргасан шийдвэрийнхээ тухай төрийн байгууллагуудад албан бичгээр мэдэгдэнэ.

6.4. ОССК нь зээлдэгчийн худалдан авах орон сууцыг барьцаанаас чөлөөлөх талаар арилжааны банкны шийдвэрийг гаргуулна.

6.5. Төрийн байгууллагаас ирүүлсэн энэхүү журмын 4.4-т заасан мэдэгдлээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн зээлдэгч зээлээ төлөөгүй тохиолдолд орон сууцыг хураан авч шүүхийн бус журмаар худалдан борлуулна.

6.6. Төрийн албан хаагчийн худалдан авах орон сууцыг сонгох бололцоо бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон орон нутагт цахим болон бусад хэлбэрээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.

6.7. ОССК нь зээлийн эргэн төлөлтийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу гүйцэтгэнэ.

Долоо. Санхүүжилт

7.1. Төрийн албан хаагчид зээлээр орон сууц худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын үнэт цаасыг үе шаттайгаар арилжаалах замаар бүрдүүлнэ.

7.2. Арилжаалах үнэт цаасны хэмжээг төрийн албан хаагчдад орон сууцны зээл олгохоор ОССК-иас гаргасан шийдвэрийн багцын дүнг үндэслэн Сангийн яам тогтооно. Зээлийн багц бүрээр Сангийн яам, ОССК-ийн хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулна.



Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд
хамруулах журмын хэвсрэлт

**ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛД ХАМРАГДАХ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ
БАРИМТЫН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх бичиг баримт
1	Төрийн албан хаагчийн зээлийн өргөдөл, анкет
2	Иргэний үнэмлэх, гэрлэлтийн баталгааны нотариатаар баталгаажуулсан хуулбар
3	Албан байгууллагын тодорхойлолт /орлого олж байгаа өрхийн бусад гишүүдэд нэгэн адил хамаарна. Тодорхойлолтод тухайн төрийн албан хаагчийн ажил, албан тушаал, ажиллаж байгаа хугацаа, цалингийн хэмжээ зэргийг тусгасан байна/
4	Нийгмийн даатгалын дэвтрийн нотариат болон нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажсан хуулбар /өрхийн орлоготой бүх гишүүдийн/
5	Өрхийн бусад орлогыг тодорхойлох баримтууд /гэр бүлийн бусад гишүүдийн бизнесийн, түрээсийн, ажил үйлчилгээний гэх мэт/
6	Орон сууц худалдах, худалдан авах гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
7	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай лавлагаа

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакция

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: tamin_medeefel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1

Индекс: 14003



Овоо хонгог тугийн хэвлэл
0 оны 03 дугаар сарын 12
№10 /631/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

346

**Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тухай хуульд
нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

346

**Улсын Их Хурлын 2010 оны
хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

356

Журам батлах тухай



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсгит хөвлөн,
Утас 329487